

## ГОВЬСҮМБЭР АЙМАГ

### “ДЭЛХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨДӨР”-ИЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Засгийн газрын 2022 оны 7 сарын 05-ны өдрийн Засгийн газрын 264 дүгээр тогтоолоор “2023, 2024 оныг Монголд зочлох жил” болгон зарласан. НҮБ-ийн Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 1980 оноос хойш жил бүрийн 9 сарын 27-ны өдрийг Дэлхийн аялал жуулчлалын өдөр болгон тэмдэглэж ирсэнтэй холбогдуулан 2022 онд тус газраас “Дэлхийн аялал жуулчлалын өдөр”-ийг угтан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

**Хугацаа:** 2022.09.05-2022.10.08

**Хамрах хүрээ:** Аймгийн хэмжээнд

**Хамтран ажилласан байгууллага:** Аймгийн ЗДТГ, аймгийн Аялал жуулчлалын холбоо

Аймгийн Засаг даргаар зохион байгуулах арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө, төсвийг батлуулсан. Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ОНХС-аас 1 930 000 төгрөг зарцуулсан.

Орон нутагт Аялал жуулчлалын салбарын төрийн бодлогыг хэрэгжилт, зохион байгуулж буй арга хэмжээний мэдээ, мэдээллийг сурталчлах хүрээнд Говьсүмбэр Байгаль орчин, Говьсүмбэр аймаг facebook, байгууллагын цахим хуудсанд [www.baigal.gs.gov.mn/](http://www.baigal.gs.gov.mn/) 15 мэдээлэл байршуулсан.

- Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага сэдвийн хүрээнд “Аялал жуулчлалын нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож, төлөвлөх нь” телевизийн хэлэлцүүлэг, ярилцлага хийж, Говьсүмбэр телевиз болон цахим хуудас, facebook-т [/http://baigal.gs.gov.mn/?p=2720/](http://baigal.gs.gov.mn/?p=2720/) байршуулан нэвтрүүлсэн. Хэлэлцүүлэгт Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сүмбэр сумын Засаг дарга, аймгийн аялал жуулчлалын холбоо, Боржигин голомт жуулчны бааз, Орцог элгэн хоршоо зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцсон.



Аялал жуулчлалын [www.mto.mn](http://www.mto.mn) сайтад аймагт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар, зочид буудлын нэгдсэн судалгааг байршуулж, үйлчилгээний салбаруудын сурталчилгааны шторк хийж цахимаар болон телевизээр сурталчилсан.

- “Зөв аялъя” самбар хийлгэж, Политехникийн коллеж, 5-р сургуулийн 30 сурагчид сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан.



Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар, зочид буудлын нэгдсэн сурталчилгааны шторк хийж цахим хуудас болон facebook-т байршуулсан.



**Орон нутгийн аялал жуулчлалын холбоо, спорт клубуудтэй хамтран ажиллах хүрээнд:**

Жил бүр жуулчдад зориулан сурагчдыг чадавхжуулах хүрээнд уламжлал болгон зохион байгуулдаг англи хэл дээр "Музей хэн сайн тайлбарлах вэ?" тэмцээнд нийт 9-12-р ангийн 20 сурагч оролцож, 1, 2, 3-р байр эзэлсэн сурагчдад Өргөмжлөл дурсгалын зүйл хадгалуулсан.

Монголын Шагай Холбоо, Говьсүмбэр аймгийн ЗДТГ, ИТХ, Зүүний Хүчний холбоо, Аймгийн Музей хамтран БОРЖИГИН ТОЙРОМ-2022 шагай харвааны тэмцээн Чойрын Богд уулын энгэрт зохион байгуулсан. “Зөв, цэвэр аялъя” уриалга гарган, ангилан ялгах хогийн сав байршуулж, ил задгай хог хаягдалгүй зохион байгуулсан.



Аймгийн сурын холбоотой хамтран ГОВИЙН БҮСИЙН ЧУУЛГА ХАРВАА-2022 үндэсний сурын багийн харваа тэмцээн зохион байгуулж, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Говьсүмбэр 5 аймгийн 10 багийн Улсын цолтой-8, Аймгийн цолтой-55, Спортын мастер-31, Дэд мастер-13, Сумын цолтой-29, 1, 2, 3-р зэргийн 14, нийт 146 харваач оролцож цэц мэргэнээ сорин аваргаа тодруулсан.

Эдгээр тэмцээний үеэр аймгийн аялал жуулчлалын танилцуулга QR кодыг сурталчлан тараасан.





## Аялал жуулчлалын салбарын ажилтнуудыг чадавхижуулах сургалт:

### Зочлох үйлчилгээний бизнес эрхлэгчдэд зориулсан СТРАТЕГИЙН СУРГАЛТ

"Говьсүмбэр аймгийн хөгжилд аялал жуулчлалын болон бизнесийн салбарын оролцоо, түүний стратеги" сэдэвт сургалтыг аймгийн аялал жуулчлал ба худалдаа үйлчилгээний байгууллагын удирдах ажилтнуудад зохион байгуулав. Сургалтыг Содура ХХК-ны гүйцэтгэх захирал [#Ц.Алтангэрэл /ОУММЗ/](#), аймгийн аялал жуулчлалын холбоо хамтран зохион байгуулсан. [#Сургалт](#) аймгийн аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний байгууллагын бизнесийн гадаад, дотоод орчны шинжилгээ, амжилтад нөлөөлөх хүчин зүйлүүдийн шинжилгээг хийж, баримтлах стратегиудыг тодорхойлж, компани бүр өөрсдийн оролцоог тодорхойлон хамтран хөгжих стратеги, бодлогоо гаргах зорилготой үр дүнтэй сургалт байсан.





## ОЮУНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран жуулчны бааз, зочид буудал, худалдаа, үйлчилгээний ажилтнуудад зориулсан "ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА ХАНДЛАГА" сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтад жуулчны бааз, зочид буудал, худалдаа үйлчилгээний салбарын нийт 27 хүн хамрагдсан. Сургалтад Улаанбаатар хот "СОДУРА КОНСАЛТИНГ" ХХК-ны зөвлөх Ж.Жаргалмаа, Э.Мөнхжин нар үйлчилгээний ажилтнуудын хувийн соёл, харилцааны соёл, хандлага зэрэг сэдвийн хүрээнд сонирхолтой мэдээлэл өгч хамтран ажилласан.







Говьсүмбэр аймгийн танилцуулга, аяллын маршрут бусад мэдээлэл бүхий гарын авлагыг **QR код** болгон цахимаар болон нийтэд ил тод байршуулан, 30 иргэн, аж ахуйн нэгжид тараасан.



“Зөв аялъя”, “Ирлээ, явлаа, цэвэр”, “Би байгальд хог хаяхгүй” зэрэг уриалга бүхий сурталчилгаа хийж, дотоодын аялагч, гадаадын жуулчдад зориулан улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уулын мэдээллийн самбрыг шинэчилсэн.

**УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ЧОЙРЫН БОГД УУЛ - БАЙГАЛИЙН НӨВЦ ГАЗАР**





**ЭРХЭМ АЯЛАГЧ ТА ДАРААХ ЭНГИЙН ҮЙЛДЛҮҮДИЙГ ХЭВШҮҮЛЭЭ ҮҮ?**

- АЯЛАНЗ ЗУГААЛАХДАА БУУДАЛЛАСАН ГАЗРАА ЦЭВЭРЛЭН, ХОГ, ХАЯГДЛАА АВЧ ЯВАН ЗОРИУЛАЛТЫН ХОГИЙН ЦЭГТ ХАЯХ
- ОЙ, ХЭЭРТ ЯВАХДАА ТҮЙМРИЙН АЮУЛААС СЭРГИЙЛЖ ТАМХИНЫ УНТРААГУЙ ИШ, ИЛ ЗАЛГАЙ ГАЛ, ҮНС НУРАМ ҮЛДЭЭХГҮЙ БАЙХ
- ЗӨВШӨВӨРӨЛГҮЙ АН АГНАЖ, БАЙГАЛИЙН НӨВЦ БАЯЛАГ АШИГЛАХГҮЙ БАЙХ
- ХОГ ХАЯГДЛАА ИЛ ЗАДГАЙ ХАЯХГҮЙ БАЙХ
- АЯЛАЛААР ЯВАХДАА ЗАМГУЙ ГАЗРААР ЗӨРЧИН ШИНЭЭР ЗАМ ҮҮСГЭХГҮЙ БАЙХ
- ШҮТЭЛЭГТЭЙ УУЛ, ОВООНДОО ЭЛДЭВ ХҮНСНИЙ ЗҮЙЛС ӨРГӨН, ТАХИЛ ШҮТЭЭНЭЭ ХОГИЙН ЦЭГ БОЛТОХГҮЙ БАЙХ
- ИЛ ЗАДГАЙ БИЕ ЗАСАХГҮЙ, ШҮЛС, НУС, БОХЬ, ТАМХИНЫ ИШИЙГ ХАЯХГҮЙ БАЙХ
- ГОЛ, УС, БУЛАГ, ШАНДАА БОХИРДУУЛАХГҮЙ, УНДАРГА ХЭММЭЭНЭЭС НЬ ХЭТРҮҮЛЭН АШИГЛАХГҮЙ БАЙХ

**ЗӨВ ХАНДЛАГА, ЗЕРЭГ ӨВРЧӨЛТИЙГ ӨВРӨСӨӨ ЭХЛҮҮЛНИ, ЭХ БАЙГАЛЬДАА ЭЭЛТЭЙ АМЬДАРЦГАА.**

ГОВЬСҮМБЭР АЙМАГ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ НУУЛЧЛАЛЫН ГАЗАР












**ИРГЭН БҮР БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ**



Чоно нь хүртэл амна даатгадаг  
Чойрын богд бурхан уул аа...

**ЗӨВ АЯЛЪЯ - ЦЭВЭР БАЙЯ - БУСДЫГ - ХҮНДЭЛЬЕ**





**ИРГЭН ТА УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ  
“ЧОЙРЫН БОГД” УУЛЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРААР  
СОЁЛТОЙ ЗОРЧИНО УУ!**

**ИРГЭНИЙ ҮҮРЭГ /Байгаль орчныг хамгаалах тухай хуулиас /**

1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ САХИН БИЕЛҮҮЛЭХ
2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ УЛАМЖЛАЛ, ЗАН ЗАНШИЛ ЭЗЭМШИЖ ХЭРЭГЛЭХ ҮР ХҮҮЖЭДДЭЭ ЭКОЛОГИЙН ХҮМҮҮЖИЛ ОЛГОХ
3. БАЙГАЛЬ ОРЧИНД ХОРТОЙ НӨЛӨӨЛӨХӨӨС СЭРГИЙЛЭХ, ӨӨРИЙН БУРУУГААС УЧРУУЛСАН ХОРТОЙ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙ ХОХИРОЛЫГ АРИЛГАХ БУЮУ НӨХӨН ТӨЛӨХ
4. БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАСАН, ГЭМТЭЭСЭН, ХӨНӨӨЖ СҮЙТГЭСЭН ҮЙЛДЛИЙГ ОЛЖ МЭДСЭН ИРГЭН ТЭР ДАРУЙ ТУХАЙН ОРОН НУТГИЙН ЗАСАГ ДАРГА, УЛСЫН БАЙЦААГЧ, БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИД НЭН ДАРУЙ МЭДЭГДЭХ ҮҮРЭГТЭЙ. БАЙГАЛЬ ОРЧНОО ХАЙРЛАН ХАМГААЛАХ НЬ ИРГЭН БҮРИЙН ЖУРАМТ ҮҮРЭГ МӨН.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Аялал жуулчлалын хөгжлийн төв  
23цаг



Говьсүмбэр телевиз  
9-р сарынын 27 өдрийн 16:59 цаг

## ҮР ДҮН:

1. “Аялал жуулчлалын нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож, төлөвлөх нь” телевизийн хэлэлцүүлэг, ярилцлага хийж, цаашдын төлөвлөлтийн санал авсан.
2. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхижуулсан.
3. Аймгийн аялал жуулчлалын салбарын нэгдсэн видео танилцуулгатай болсон.
4. Аймгийн сурын болон шагайн харваан холбоотой хамтран ажиллаж, аймаг орон нутгаа сурталчлан, дотоодын аялагчдыг нэмэгдүүлсэн. /Нийт 300 гаруй бусад аймгийн аялагч/
5. 2 байгууллага, 65 иргэнд мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулсан.
6. Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уулын мэдээллийн самбарыг шинэчилсэн.

Тайлан гаргасан:

Ахлах мэргэжилтэн

Б.Гандулам